

ТӨВ АЗИЙН ӨНДӨРЛӨГИЙНХЭН БА ИНДИАНЧУУД

*М.Хурметхан**

Археологийн шинжлэх ухаан индианчуудыг одоогоос 40000 жилээс өмнө Ази тивээс үе үе Берингийн хүзүүвчээр дамжин шилжин суурьшсан гэж үздэг юм. Гурван удаагийн далайн усны таралтаар Берингийн хоолой ил гарч, түүгээр хүмүүс дамжин нүүдэлжээ. Судлаачдын үзэж байгаагаар Берингийн хоолойгоор дамжсан тэдгээр хүмүүс өөрийн удам угсаа, хэл, соёлоо авч явжээ. Өнөөдрийн индианчууд антропологийн хэв шинжийн хувьд монголжуу төрхтөн америк угсаатанд хамаарагдана. Арьсны өнгө хүрэн шар, үс нь шулуун ба хатуу, сахал нь сийрэг, эрүүний яс нь өргөгдсөн, нүдний ухархай гүнзгий, дээд шүдний доторхи том хонхор зэрэг нь үүнийг гэрчилдэг байна. АНУ болон ОХУ-ын эрдэмтдийн өгөрсөн зууны сүүлээс эхлэн явуулсан генетикийн судалгаагаар индианчуудын ДНК молекул дахь гарвал угсааны мэдээлэлийн сан нь Төв Азийн Алтайн уулын дахь түрэг хэлтэн ард түмний генофондтой байгууламжтай адил болохыг нотолжээ. Энэхүү баталгаа бол индиан-түрэг, индиан-монгол хэлтнүүдийн хооронд ижил төстэй зүйл олон байдаг талаархи зарим мэдээлэлийг улам баталгаажуулан баяжуулсан байна. Профессор Адам Нордуолл нь Төв Азийн өндөрлөгт аж төрж ирсэн эртний аймгуудын зан зүйл, дүр төрх, хэл, соёлын байдлаараа эскимосуудтай адил байгааг нотолжээ. Аляскийн хойгийн Сибирь өөдөөс харсан тал нь эрт үеэс эхлэн Азиас Америк тив руу орох хаалга байжээ хэмээн үздэг билээ. Аляскийн оршин суугчид Төв Азийн хүмүүс харилцаа холбоотой байлаа. Эскимосууд ан агнах, загас барьж аж төрсөөр Берингийн тэнгисийн хөвөө, Артикийн эрэг г.м. газаруудаар нутаглажээ.

Индианчуудын олон омог аймаг Төв Ази Сибириэс гаралтай болох тухай америкийн астронологич Алеш Хирдличек нь индианчуудын жинхэнэ өвөг дээдэс нь Байгаль нуур орчимд чулуун зэвсгийн үед аж төрж байсан хүн амаас улбаатай гэжээ. Мөн ОХУ-ын эрдэмтэд А.П. Окладников, А.П. Деревянко нарын судалгаанд мөн ийнхүү байдлаар тусгалаа олжээ. Эрдэмтдийн судалсанаар Америк тивд индиан 123 хэлний бүлэг бүхий омог аймаг байдаг ажээ. Мөн хойд Америкийн дорнод этгээдээр нутагладаг индианы тлинкит, өмнөд Америкт чоно гм нэртэй овог ч байна.

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Индианчуудын Төв Азийн өндөрлөгийнхэнтэй удам гарал, хэл, соёлоор холбоотой төдийгүй МЭ IV-VIII зуунд Аляскийнхан Хөх Түрэгийн хаант улстай харилцаатай байв. Тухайлбал, Билгэ хааны хөшөөний 3 дахь нүүрийн өмнө талд “Зүүнээ **шөно дунд** болох лүүгээ түүн дотор харъяат олон надад захирагдах, ийм харъяатыг хотол болгов”¹ гэж тэмдэглэсэн байдаг. Уг хөшөөнд Хөх Түрэгийн хаант улсын цэрэг баруун талд Төмөр хаалга /Тажикстан /, дорно зүг Шаньдунгийн талд хүрч, өмнө зүг Төвдөд бага зэрэг хүрсэнгүй гэсэн байдаг. Харин хойт талдаа хүрсэн **шөно дунд** -ыг захирсан гэсэн нь ямар нутаг болохыг эрдэмтэд одоо хүртэл анзаараагүй байна. Гэтэл Аляскийг орон нутгийн индиан, эскимосууд одоо ч шөно дундын нутаг “Micknames The Last Frontier Land of the Midnighth Sun”² гэдэг байна. Үүнээс үзэхэд, Хөх Түрэгийн хаант улсынхан Аляскид хүрсэн гэж үзэж болохоор байна.

“Нууц товчоо”-д чинос, төлес, тэлэнгэд аймгийн тухай гардаг бөгөөд тэд Эрчис мөрнөөс ойн иргэн хүртэлх нутаг байсан бололтой байдаг байна. Тэлэнгид нар Төв Азийн эртний аймаг бөгөөд Хойт Америкийн Тэленгит омгийн индианчуудын овог гэж үздэг тал бас байдаг.

Харин одоо, Америкийн индианууд болон Сибирийнхэн нэг гарал үүсэлтэй болохыг генетикийн шинжлэх ухаан нотолж байна. Дэвис дахь Калифорнийн Их Сургуулийн хэсэг эрдэмтэд Хойт Америкийн индианууд болон Оросын дорнод хэсгийн уугуул оршин суугчдын ДНК-д өвөрмөц уламжлал тогтолцоо байгааг саяхан тогтоов. Тухайлбал, ДНК-ийн арваад цуваан дахь давтамж нь, 9RA гэж нэрлэгддэг цуваа нь судлагдсан Хойт Америкийн индианууд болон Дорнод Сибирийн уугуул оршин суугчдад ижил байгаа нь харагджээ. Мөн энэ 9RA нь судлагдсан Азийн бусад ард түмнүүдийн ДНК-д тохиолдоггүй байна.³ Энэхүү нээлт нь индианууд Берингийн хоолойгоор нүүн одсон гэдэг таамаглалыг батлах бас нэгэн нотолгоо болж байна юм. Мөн Хойт Америкийн индианчуудыг хэл, шүдний бүтэц зэргийг судалсан зарим эрдэмтдийн индианы овог бүр өөр өөр гаралтай үүсэлтэй байсан гэж үзэж байсныг энэхүү нээлт няцааж, харин тэд нэгдмэл нэгэн гарал үүсэлтэй болохын хамтаар, Дорнод Сибирь- Байгаль нуурын оршин суугчдын эртний өвөг дээдсээр дамжин Төв Азийн өндөрлөгийнхэнтэй нэн эртний нэгэн гарвалтай болох нь тодорхой болж байна.

Эшлэл, зүүлт

1. Anthology of Orkhon Turkic Inscriptios. UB.2006. p.28
2. American Studies.С-П.,2002., с.27
3. RFE/RL.19.02.2007